



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг.
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр.
Утас/факс: (976-11) 329084
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2014.03.29 № 1 / 1384

танай _____-ны № _____-т


УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Б.ГАРАМГАЙБААТАР ТАНАА

Банк бус санхүүгийн байгууллагуудын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулгыг хураангуй тайлан тэнцэл, орлого үр дүнгийн тайлангийн хамт хүргүүлж байна.

Хавсралт 32 хуудас.

Хүндэтгэсэн,

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000000

АГУУЛГА

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
2013 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

| | |
|---|-------|
| <i>Нэг. ББСБ-ын салбарын өнөөгийн байдал</i> | 2-4 |
| <i>Хоёр. Нэгтгэлийн статистик үзүүлэлт</i> | 4-7 |
| 2.1 Ерөнхий статистик үзүүлэлт | 4-5 |
| 2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ | 5-6 |
| 2.3 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ | 6-7 |
| 2.4 Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэн явуулж буй ББСБ | 7 |
| <i>Гурав. Активын бүтэц, чанар, зээлийн үйл ажиллагаа</i> | 7-11 |
| 3.1 Активын бүтэц, өөрчлөлт | 7-9 |
| 3.2 Зээлийн багцын чанар | 9-10 |
| 3.3 Зээлийн хүү | 10-11 |
| 3.4 Активын бусад үзүүлэлтийн талаар | 11 |
| <i>Дөрөв. Пассивын бүтэц, өөрчлөлт</i> | 11-14 |
| <i>Тав. Орлого, зарлага, ашигт ажиллагаа</i> | 14-17 |
| <i>Зургаа. ББСБ-уудыг активын хэмжээгээр нь бүлэглэсэн байдал, бүлгүүдийн санхүүгийн тоон үзүүлэлтүүд</i> | 17 |
| <i>Долоо. Салбарын зохистой харьцааны тоон үзүүлэлт</i> | 17-18 |
| <i>Найм. Дүгнэлт</i> | 18-19 |
| <i>Ес. Цаашид авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ</i> | 19 |

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
2013 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2014.03.13

Улаанбаатар хот

НЭГ. ББСБ-ЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Тайлант жилд Хорооны хуралдаанаар 108 ББСБ-ын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 54 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 3 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгосноор тайлант хугацааны эцэст нийт 263 ББСБ Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байна.

2006 оны жилийн эцсийн тайлант хугацаанаас хойш ББСБ-уудын тоонд дараах өөрчлөлт орсон байна.

/Хүснэгт 1/

| № | Тайлант хугацаа | Тайлант хугацааны эцэс дэх ББСБ-ын тоо | Үүнээс: | | |
|---|-----------------|--|---|-----------------------------------|---|
| | | | Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ | Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ | Зөвхөн гадаад валютын арилжаа эрхэлж буй ББСБ |
| 1 | 2006 он | 139 | - | - | - |
| 2 | 2007 он | 137 | - | - | - |
| 3 | 2008 он | 132 | 23 | 11 | - |
| 4 | 2009 он | 177 | 27 | 9 | 47 |
| 5 | 2010 он | 182 | 26 | 15 | 48 |
| 6 | 2011 он | 195 | 23 | 17 | 39 |
| 7 | 2012 он | 212 | 24 | 17 | 38 |
| 8 | 2013 он | 263 | 31 | 19 | 41 |

Хорооны хуралдаанаар тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын асуудлуудыг хэрхэн шийдвэрлэсэн байдлыг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт 2/

| № | Тайлант хугацаа | Тусгай зөвшөөрөл шинээр олгосон | Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон | Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн | Тусгай зөвшөөрлийг сэргээсэн | Тайлант хугацааны эцэс дэх ББСБ-ын тоо |
|---|-----------------|---------------------------------|--------------------------------------|----------------------------------|------------------------------|--|
| 1 | 2006 он | 2 | 24 | - | - | 139 |
| 2 | 2007 он | 10 | 12 | - | - | 137 |
| 3 | 2008 он | 10 | 15 | - | - | 132 |
| 4 | 2009 он | 56 | 11 | 15 | 9 | 177 |
| 5 | 2010 он | 20 | 15 | 20 | 7 | 182 |
| 6 | 2011 он | 32 | 19 | 14 | 8 | 195 |
| 7 | 2012 он | 23 | 6 | 4 | 2 | 212 |
| 8 | 2013 он | 54 | 3 | 3 | 1 | 263 |

Тайлант 2013 онд 54 компанид нийт 19,908,302.9 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон бөгөөд тухайлвал Баянхонгор аймагт 3, Төв аймагт 2, Баян-Өлгий, Сэлэнгэ, Завхан аймагт тус бүр 1 ББСБ тус бүр 50.0 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр, Улаанбаатар хотод 46 ББСБ 100.0-1,900.0 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр зээл, гадаад валютын арилжаа, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байна.

ББСБ-уудын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

2013 онд Хорооны хуралдаанаар 3 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 1 ББСБ-ын тусгай зөвшөөрлийн төрлийг сэргээж, 3 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгон, 2 ББСБ-ын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны төрлийг хүчингүй болгон, 7 ББСБ-д тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны төрлийг нэмж олгосон.

Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тооны өөрчлөлтийг графикаар үзүүлбэл:



ББСБ-уудыг Монгол Улсын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа, үйлчилгээ эрхэлж буйгаар нь ангилвал:

/Хүснэгт 3/

| № | Үйл ажиллагааны нэр төрөл | Үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тоо | |
|----|---|--------------------------------------|--------------------|
| | | 2012 оны IV улирал | 2013 оны IV улирал |
| 1 | Гадаад валютын арилжаа эрхэлдэг нийт | 94 | 104 |
| | Үүнээс: зөвхөн гадаад валютын арилжааг дагнан эрхэлдэг | 38 | 41 |
| 2 | Зээл | 171 | 219 |
| 3 | Факторингийн үйлчилгээ | 12 | 13 |
| 4 | Төлбөрийн баталгаа гаргах | 8 | 9 |
| 5 | Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах | 0 | 0 |
| 6 | Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ | 5 | 5 |
| 7 | Итгэлцлийн үйлчилгээ | 18 | 21 |
| 8 | Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх | 2 | 2 |
| 9 | Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх | 18 | 21 |
| 10 | Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа | 0 | 0 |
| 11 | Хөрөнгө оруулалтын үйлчилгээ ¹ /Венчур хөрөнгө оруулалт/ | 1 | - |

2013 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн тусгай зөвшөөрөлтэй 263 ББСБ-ын 83.2 хувь нь зээл, 39.5 хувь нь гадаад валютын арилжаа /15.6 хувь нь гадаад валютын арилжааг дагнан эрхэлдэг/, 8.0 хувь нь хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, 1.9 хувь нь цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, 4.9 хувь нь

¹Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заагдсан тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд хамаарахгүй бөгөөд Хорооны 2009 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 185 дугаар тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн байгууллагаас хөрөнгө оруулалтын үйлчилгээ үзүүлэх түр журам"-ыг үндэслэн Эн Ви Си ББСБ-д уг үйлчилгээг эрхлэх зөвшөөрлийг олгосон. ББСБ-уудын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

факторингийн үйлчилгээ, 3.4 хувь нь төлбөрийн баталгаа гаргах, 8.0 хувь нь итгэлцлийн үйлчилгээ, 0.8 хувь нь богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээг тус тус эрхлэн явуулж байна.

ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ

2.1. Ерөнхий статистик үзүүлэлтүүд:

Өмнөх оны жилийн эцсийн голлох статистик үзүүлэлтүүдийг 2013 оны жилийн эцсийн тайлант хугацаатай харьцуулж харуулбал: Үүнд

| № | Үндсэн үзүүлэлтүүд | 2012 оны жилийн эцэст | 2013 оны жилийн эцэс | Өсөлт +/-, бууралт -/ |
|---|--|-----------------------|----------------------|-----------------------|
| 1 | ББСБ-ын тоо | 212 | 263 | 51 |
| 2 | Хувьцаа эзэмшигчдийн тоо | 599 | 762 | 163 |
| 3 | Ажиллагсадын тоо | 1,193 | 1,396 | 203 |
| 4 | Салбар нэгжийн тоо | 69 | 84 | 15 |
| 5 | Харилцагчдын тоо | 483,015 | 2,050,590 | 1,567,575 |
| 6 | Нийт актив /мянган төгрөгөөр/ | 252,053,541.4 | 381,130,752.7 | 129,077,211.3 |
| <i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i> | | <i>2.10%</i> | <i>1.82%</i> | <i>-0.28%</i> |
| 7 | Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/ | 157,769,345.8 | 223,711,713.9 | 65,942,368.1 |
| <i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i> | | <i>2.24%</i> | <i>2.06%</i> | <i>-0.18%</i> |
| 8 | Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/ | 171,296,659.6 | 234,337,952.6 | 63,041,293.0 |
| <i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i> | | <i>17.38%</i> | <i>17.70%</i> | <i>0.32%</i> |
| 9 | Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/ | 139,194,226.2 | 183,691,627.8 | 44,497,401.6 |
| <i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i> | | <i>44.94%</i> | <i>50.59%</i> | <i>5.65%</i> |
| 10 | Итгэлцлийн үйлчилгээний өглөг /мянган төгрөгөөр/ | 14,111,454.9 | 19,074,014.6 | 4,962,559.7 |
| 11 | Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл /мянган төгрөгөөр/ | 46,142,177.6 | 90,226,226.1 | 44,084,048.5 |
| | Үүнээс: Богино хугацаат зээл/мянган төгрөгөөр/ | 25,469,545.7 | 63,470,381.0 | 38,000,835.3 |
| | Урт хугацаат зээл /мянган төгрөгөөр/ | 20,672,631.9 | 26,755,845.1 | 6,083,213.2 |
| 12 | Төслийн зээлийн санхүүжилт /мянган төгрөгөөр/ | 7,977,378.4 | 11,917,167.1 | 3,939,788.7 |
| 13 | Нийт орлого /мянган төгрөгөөр/ | 116,157,189.5 | 106,652,086.0 | 36,168,975.2 |
| 14 | Нийт зардал /мянган төгрөгөөр/ | 51,903,731.8 | 76,817,416.7 | 24,913,684.9 |
| 15 | Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/ | 18,579,379.1 | 29,834,669.3 | 11,255,290.2 |

2013 оны жилийн эцсийн байдлаар ББСБ-уудын нийт актив оны эхнээс 51.2 хувиар өссөн бөгөөд энэхүү өсөлтөд хувь нийлүүлсэн хөрөнгө 45.8 тэрбум төгрөгөөр тухайлвал тайлант хугацаанд шинээр тусгай зөвшөөрөл авсан 54 ББСБ-ын нийт хувь нийлүүлсэн хөрөнгө 19.9 тэрбум төгрөг, тайлант хугацаанаас өмнө тусгай зөвшөөрөлтэй байсан ББСБ-ууд нийт 25.9 тэрбум төгрөгөөр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүндээ өөрчлөлт оруулсан буюу нэмэлт хөрөнгө оруулалт, хуримтлагдсан ашгаар нэмэгдүүлсэн нь нөлөөлсөн.


Тайлант хугацаанд ББСБ-уудын нийт актив 381.1 тэрбум төгрөг, зээлийн өрийн үлдэгдэл 223.7 тэрбум төгрөг, эзэмшигчдийн өмч 234.3 тэрбум төгрөг, дүрмийн сан 183.7 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын үзүүлэлтүүдтэй харьцуулахад нийт активын 1.8 хувьтай, зээлийн өрийн үлдэгдлийн 2.1 хувьтай, эзэмшигчдийн өмчийн 17.7 хувьтай, дүрмийн сангийн 50.6

хувьтай тус тус тэнцэж байна. ББСБ-д ажиллах боловсон хүчний тоо 1,396 , харилцагчдын тоо 2,050,590 –д хүрсэн байна.

2013 оны жилийн эцсийн байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөлтэй 263 ББСБ байгаагийн 88.2 хувь буюу 232 ББСБ нь УБ хотод, 11.8 хувь буюу 31 ББСБ нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

ББСБ-уудын байршлыг графикаар үзүүлбэл:

/график 2/



2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ:

2013 оны жилийн эцсийн байдлаар орон нутагт төвтэй 31 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 11.8 хувийг, тэдгээрийн актив нь нийт ББСБ-ын активын 1.9 хувийг, олгосон зээл, түүнтэй адилтган тооцох актив нь нийт ББСБ-ын зээлийн үлдэгдлийн 2.5 хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчдийн өмчийн 3.0 хувийг, хувь нийлүүлсэн хөрөнгө нь нийт ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн 2.6 хувийг тус тус эзэлж байна. Үүнд:

/Хүснэгт 5/

| № | Үндсэн үзүүлэлтүүд | 2012 оны жилийн эцэс | 2013 оны жилийн эцэс | Өсөлт +/-, бууралт +/- |
|---|--|----------------------|----------------------|------------------------|
| | Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо | 24 | 31 | +7 |
| | ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь | 12.12% | 11.79% | -0.33% |
| А | Нийт актив /мянган төгрөгөөр/ | 6,254,321.4 | 7,290,763.8 | 1,036,442.4 |
| | ББСБ-ын нийт активт эзлэх хувь | 2.48% | 1.91% | -0.57% |
| Б | Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/ | 4,802,425.5 | 5,563,418.6 | 760,993.1 |
| | ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь | 3.04% | 2.49% | -0.55% |
| | Чанаргүй зээл /мянган төгрөгөөр/ | 111,512.1 | 155,111.4 | 43,599.3 |
| В | Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/ | 5,655,029.6 | 6,946,731.2 | 1,291,701.6 |
| | ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь | 3.30% | 2.96% | -0.34% |
| Г | Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/ | 4,434,871.2 | 4,751,150.4 | 316,279.2 |
| | ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь | 3.19% | 2.59% | -0.60% |
| Д | Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл /мянган төгрөгөөр/ | 164,555.6 | 153,833.0 | -10,722.6 |
| | Үүнээс: Богино хугацаат зээл /мянган төгрөгөөр/ | - | 100,000.0 | 100,000.0 |
| | Урт хугацаат зээл /мянган төгрөгөөр/ | 164,555.6 | 53,833.0 | -110,722.6 |
| Е | Төслийн зээлийн санхүүжилт /мянган төгрөгөөр/ | 134,999.7 | 74,999.7 | -60,000.0 |
| Ё | Нийт орлого /мянган төгрөгөөр/ | 1,429,326.0 | 1,845,822.8 | 416,496.8 |
| Ж | Нийт зардал /мянган төгрөгөөр/ | 665,603.0 | 869,434.1 | 203,831.0 |

ББСБ-уудын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

| | | | | |
|---|---------------------------------------|-----------|-----------|-----------|
| 3 | Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/ | 763,722.9 | 976,388.7 | 212,665.8 |
|---|---------------------------------------|-----------|-----------|-----------|

Хорооноос орон нутагт үйл ажиллагаа явуулж буй бичил санхүүгийн байгууллагуудын тоог нэмэгдүүлэх, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх ажлын хүрээнд орон нутагт үйл ажиллагаа явуулах ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг ялгавартай тогтоосон хэдий ч орон нутагт бичил санхүүгийн үйлчилгээний ач тусын талаар ойлголт муу, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээлэл, сурталчилгаа хангалтгүй байгаагаас өсөлтийн түвшин бага байна.

2.3 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ:

2013 оны жилийн эцсийн байдлаар гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 19 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 7.2 хувийг, тэдгээрийн нийт актив ББСБ-ын нийт активын 13.4 хувийг, олгосон зээл нь нийт ББСБ-уудын олгосон зээлийн 14.9 хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ-уудын эзэмшигчдийн өмчийн 14.5 хувийг, хувь нийлүүлсэн хөрөнгө нь нийт ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн 14.0 хувийг тус тус эзэлж байна.

| /Хүснэгт 6/ | | | | |
|-------------|--|-----------------------|-----------------------|------------------------|
| № | Үндсэн үзүүлэлтүүд | 2012 оны жилийн эцэст | 2013 оны жилийн эцэст | Өсөлт +/-, бууралт +/- |
| | Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын тоо | 17 | 19 | +2 |
| | <i>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</i> | 8.49% | 7.22% | -1.27% |
| А | Нийт актив /мянган төгрөгөөр/ | 44,357,733.6 | 51,084,405.1 | 6,726,671.5 |
| | <i>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</i> | 17.60% | 13.40% | -4.20% |
| Б | Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/ | 29,287,989.7 | 33,411,560.2 | 4,123,570.5 |
| | Үүнээс: Чанаргүй зээл /мянган төгрөгөөр/ | 2,077,091.0 | 2,079,200.1 | 2,109.1 |
| | <i>ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i> | 18.56% | 14.93% | -3.63% |
| В | Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/ | 29,658,596.3 | 33,952,471.0 | 4,293,874.7 |
| | <i>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</i> | 17.31% | 14.49% | 2.82% |
| Г | Нийт дүрмийн сан /мянган төгрөгөөр/ | 23,698,562.5 | 25,700,362.5 | 2,001,800.0 |
| | <i>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</i> | 17.19% | 14.00% | -3.19% |
| Д | Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл /мянган төгрөгөөр/ | 9,981,488.9 | 12,153,010.7 | 2,171,521.8 |
| | Үүнээс: Богино хугацаат зээл /мянган төгрөгөөр/ | 6,260,651.1 | 6,863,131.2 | 602,480.1 |
| | Урт хугацаат зээл /мянган төгрөгөөр/ | 3,720,837.8 | 5,289,879.6 | 1,569,041.8 |
| Е | Төслийн зээлийн санхүүжилт /мянган төгрөгөөр/ | 248,890.6 | 1,005,000.0 | 756,109.4 |
| Ё | Нийт орлого /мянган төгрөгөөр/ | 11,078,371.0 | 15,086,690.0 | 4,008,319.0 |
| Ж | Нийт зардал /мянган төгрөгөөр/ | 9,233,042.6 | 12,139,673.4 | 2,906,630.8 |
| З | Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/ | 1,845,328.4 | 2,947,016.7 | 1,101,688.3 |

Гадаадын хөрөнгө оруулагчдыг харьяаллаар нь авч үзвэл Япон улсын хөрөнгө оруулалттай 10, БНСУ-ын хөрөнгө оруулалттай 4, АНУ-ын хөрөнгө оруулалттай 2, Итали, ОХУ, БНХАУ, Швейцарийн хөрөнгө оруулалттай тус бүр 1 ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

2013 онд эхний 11 сарын хугацаанд гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдоогүй бөгөөд энэ нь Улсын Их Хурлын 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай” хууль батлагдсанаар гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход Улсын Их Хурал, Засгийн газраас хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дараа шийдвэрлэхээр заасантай холбоотой байсан.

Улсын Их Хурлаас “Хөрөнгө оруулалтын тухай” хуулийг батлан 2013 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөхөөр хуульчилснаар “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах ББСБ-уудын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

тухай” хуулийг 2013 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс хүчингүй болгосон бөгөөд Хорооноос тусгай зөвшөөрөл авахаар хүсэлтээ ирүүлсэн нэр бүхий 2 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгон, 2 компанийн хүсэлтийг шийдвэрлэхээс татгалзан, мөн нэр бүхий 2 компанийн баримт бичгүүдийг холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу хянаж байна.

2.4 Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэн явуулж буй ББСБ:

Тайлант хугацаанд буюу 2013 оны жилийн эцсийн байдлаар нийт 54 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгосноос 16.7 хувь буюу 9 ББСБ-д банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон.

Хорооноос тусгай зөвшөөрөл авсан нийт 263 ББСБ-ын 104 ББСБ буюу 39.5 хувь нь гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгаагаас дотор 41 ББСБ нь зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг дагнан эрхлэх зөвшөөрөлтэй байна.

Гадаад валютын арилжаа дангаар эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 41 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 15.6 хувийг, тэдгээрийн актив нийт ББСБ-ын активын 2.2 хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчдийн өмчийн 3.5 хувийг, хувь нийлүүлсэн хөрөнгө нь нийт ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн 3.7 хувийг тус тус эзэлж байна.

| № | Үндсэн үзүүлэлтүүд | /Хүснэгт 7/ | | |
|---|---|-----------------------|-----------------------|------------------------|
| | | 2012 оны жилийн эцэст | 2013 оны жилийн эцэст | Өсөлт /+/, бууралт /-/ |
| | Валютын арилжааны үндсэн үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо | 38 | 41 | +3 |
| | <i>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</i> | 17.92% | 15.59% | -2.33% |
| А | Нийт актив /мянган төгрөгөөр/ | 8,105,754.7 | 8,478,323.8 | 372,569.1 |
| | <i>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</i> | 3.21% | 2.22% | -0.99% |
| Б | Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/ | 7,547,277.0 | 8,323,756.7 | 776,479.7 |
| | <i>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</i> | 4.40% | 3.55% | -0.85% |
| В | Нийт дүрмийн сан /мянган төгрөгөөр/ | 6,281,692.4 | 6,758,692.4 | 477,000.0 |
| | <i>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</i> | 4.51% | 3.68% | -0.83% |
| Г | Төслийн зээлийн санхүүжилт /мянган төгрөгөөр/ | 9,981,488.90 | - | - |
| Д | Нийт орлого /мянган төгрөгөөр/ | 8,688,029.3 | 1,477,994.5 | -7,210,034.8 |
| Е | Нийт зардал /мянган төгрөгөөр/ | 8,136,914.4 | 1,140,176.3 | -6,996,738.1 |
| Ё | Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/ | 551,114.9 | 337,818.2 | -213,296.7 |

ГУРАВ. АКТИВЫН БҮТЭЦ, ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 Активын бүтэц, өөрчлөлт:

Тайлант жилд нийт ББСБ-уудын активын бүтэц өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад дараах байдалтай байна.

| № | ХӨРӨНГӨ | 2012.12.31 | | 2013.12.31 | | Өөрчлөлт | |
|---|--|----------------------|-------------|----------------------|-------------|----------------------|-------------|
| | | Дүн /мян.төг/ | Хувь % | Дүн /мян.төг/ | Хувь % | Дүн /мян.төг/ | Хувь % |
| А | Эргэлтийн хөрөнгө | 242,772,323.2 | 96.3 | 368,558,057.8 | 96.7 | 125,785,734.6 | 51.8 |
| 1 | Мөнгөн хөрөнгө | 66,678,881.6 | 26.4 | 113,684,987.5 | 29.8 | 47,006,105.9 | 70.5 |
| 2 | Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/ | 2,202,258.2 | 0.9 | 9,892,190.2 | 2.6 | 7,689,932.0 | 349.2 |
| 3 | Нийт зээл | 157,769,345.8 | 62.6 | 223,711,713.9 | 58.7 | 65,942,368.1 | 41.8 |
| | (Зээлийн эрсдлийн сан) | 4,459,428.6 | 1.8 | 6,411,883.8 | 1.7 | 1,952,455.2 | 43.8 |
| 4 | Нийт санхүүгийн түрээсийн тооцооны авлага | 547.8 | 0.0 | - | - | -547.8 | -100.0 |

ББСБ-уудын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

| | | | | | | | |
|----------|---|----------------------|--------------|----------------------|--------------|----------------------|-------------|
| | (Санхүүгийн түрээсийн эрсдлийн сан) | - | - | - | - | - | - |
| 5 | Нийт факторингийн тооцооны авлага | 843,620.0 | 0.3 | 824,620.0 | 0.2 | -19,000.0 | -2.3 |
| | (Факторингийн авлагын эрсдлийн сан) | 0.0 | 0.0 | 1,500.0 | 0.0 | 1,500.0 | 100.0 |
| 6 | Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/ | 919,838.1 | 0.4 | 797,821.3 | 0.2 | -122,016.8 | -13.3 |
| 7 | Бусад хөрөнгө | 18,817,260.2 | 7.5 | 26,060,108.8 | 6.8 | 7,242,848.6 | 38.5 |
| 8 | Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн авлага | - | - | - | - | - | - |
| Б | Эргэлтийн бус хөрөнгө | 9,281,218.2 | 3.7 | 12,572,694.9 | 3.3 | 3,291,476.7 | 35.5 |
| 9 | Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө /цэврээр/ | 9,281,218.2 | 3.7 | 12,572,694.9 | 3.3 | 3,291,476.7 | 35.5 |
| | Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө | 12,062,833.0 | 4.8 | 16,391,865.1 | 4.3 | 4,329,032.1 | 35.9 |
| | (Хуримтлагдсан элэгдэл) | 2,781,614.8 | 1.1 | 3,819,170.2 | 1.0 | 1,037,555.4 | 37.3 |
| | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 252,053,541.4 | 100.0 | 381,130,752.7 | 100.0 | 129,077,211.3 | 51.2 |


2013 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн тусгай зөвшөөрөлтэй 263 ББСБ нь 381,130,752.7 мянган төгрөгийн актив хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа явуулж байгаа ба активын өсөлт нь 2012 оны жилийн эцсийн байдлаас 129,077,211.3 мянган төгрөгөөр буюу 51.2 хувиар өссөн байна.

/График 3/



Тайлант хугацаанд нийт активын 96.7 хувь нь эргэлтийн хөрөнгө, 3.3 хувь нь эргэлтийн бус хөрөнгө байх ба активын голлох үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

/График 4/



3.2 Зээлийн багцын чанар:

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.


/Хүснэгт 9/

| № | Ангилал | 2012.12.31 | | 2013.12.31 | | Өөрчлөлт | |
|---|------------------------|----------------------|--------------|----------------------|--------------|---------------------|-------------|
| | | Дүн /мян.төг/ | Хувь % | Дүн /мян.төг/ | Хувь % | Дүн /мян.төг/ | Хувь % |
| 1 | Хэвийн | 147,077,072.0 | 93.2 | 205,075,622.1 | 91.7 | 57,998,550.1 | 39.4 |
| 2 | Хугацаа хэтэрсэн | 4,224,854.5 | 2.7 | 10,094,972.8 | 4.5 | 5,870,118.3 | 138.9 |
| 3 | Чанаргүй зээл. Үүнээс | 6,467,419.3 | 4.1 | 8,541,119.0 | 3.8 | 2,073,699.7 | 32.1 |
| | Хэвийн бус | 2,063,839.7 | 1.3 | 2,189,391.8 | 1.0 | 125,552.1 | 6.1 |
| | Эргэлзээтэй | 1,383,893.7 | 0.9 | 2,798,841.3 | 1.3 | 1,414,947.6 | 102.2 |
| | Муу | 3,019,685.8 | 1.9 | 3,552,885.9 | 1.6 | 533,200.0 | 17.7 |
| | (Зээлийн эрсдлийн сан) | 4,459,428.5 | 2.8 | 6,411,883.8 | 2.9 | 1,952,455.3 | 43.8 |
| | Нийт зээл | 157,769,345.8 | 100.0 | 223,711,713.9 | 100.0 | 65,942,368.1 | 41.8 |


2013 оны жилийн эцсийн байдлаарх зээлийн үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нийт зээлийн хэмжээ 65,942,368.1 мянган төгрөгөөр буюу 41.8 хувиар нэмэгдсэн байх ба нийт зээлийн багцад эзлэх хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн эзлэх хувь 6.8-аас 8.3 хувьд хүрч өссөн байна. Зээлийн ангилал дахь чанаргүй зээлийн эзлэх хувь 4.1-ээс 3.8 хувьд хүрч буурсан үзүүлэлттэй байна.

ББСБ-уудын нийт зээлийн багцын бүтцийг өмнөх онуудтай харьцуулбал дараах байдалтай байна.

/График 5/



/График 6/



Графикаас үзэхэд зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь 2009 онд хамгийн өндөр 8.8 хувийн үзүүлэлттэй байсан бол тайлант хугацаанд буюу 2013 оны жилийн эцэст 3.8 хувьд хүрч сүүлийн 4 жилийн хугацаанд чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь жил бүр буурсан үзүүлэлттэй байна.

Тайлант хугацаанд үүссэн чанаргүй зээлийг тодруулвал дараах байдалтай байна.

Тайлант хугацаанд 219 ББСБ нь Хорооноос банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэхээр тусгай зөвшөөрөл авсан байх ба эдгээрийн 7.3 хувь буюу 16 ББСБ нь зээлийн үйл ажиллагаагаа эрхлээгүй, 203 ББСБ нь нийт 223,711,713.9 мянган төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байна. Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 3.8 хувь нь буюу 8,516,119.0 мянган төгрөг нь чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл байх ба чанаргүй зээлийн өрийн үлдэгдлийн нийт зээлийн багцад эзлэх хувь хэмжээ дараах байдалтай байна. Үүнд:

/Хүснэгт 10/

| Нийт зээлийн хэмжээ | | Үүнээс: Чанаргүй зээл | | Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн үлдэгдэл | | | | | |
|--------------------------------|-----------------------------------|--------------------------|-----------------------------------|--|-----------------------------------|---------------|-----------------------------------|----------------|-----------------------------------|
| | | | | 0-5 % хүртэл | | 5-10 % хүртэл | | 10 % -иас дээш | |
| ББСБ-ын тоо | Чанаргүй зээлийн хэмжээ /мян.төг/ | ББСБ-ын тоо | Чанаргүй зээлийн хэмжээ /мян.төг/ | ББСБ-ын тоо | Чанаргүй зээлийн хэмжээ /мян.төг/ | ББСБ-ын тоо | Чанаргүй зээлийн хэмжээ /мян.төг/ | ББСБ-ын тоо | Чанаргүй зээлийн хэмжээ /мян.төг/ |
| 219 | 223,711,713.9 | 84 | 8,516,119.0 | 41 | 1,967,527.2 | 12 | 737,288.6 | 31 | 5,811,303.1 |
| Нийт зээлийн багцад эзлэх хувь | | 3.8% | | 0.9 % | | 0.3 % | | 2.6 % | |


3.3 Зээлийн хүү:

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй нийт 263 ББСБ-аас 83.3 хувь буюу 219 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба эдгээр компаниудын зээлийн сарын хамгийн дээд хүү 9.0 хувь, хамгийн бага хүү 0.5 хувь байна.

ББСБ-уудын зээлийн сарын дундаж дээд хүү 4.02 хувь, зээлийн дундаж доод хүү 2.23 хувь буюу нийт ББСБ-ын зээлийн сарын дундаж хүү 3.13 хувьтай байна.

ББСБ-ын зээлийн хүүг банкны зээлийн хүүтэй харьцуулбал дараах байдалтай байна.

/График 7/



3.4 Активын бусад үзүүлэлтийн талаар:

Богино хугацаат хөрөнгө оруулалтын /цэврээр/ дансны үлдэгдэлд 9,916,452.1 мянган төгрөг байх ба үүний 0.2 хувь нь буюу 25,566.5 мянган төгрөг нь арилжааны үнэт цаас, 99.7 хувь нь буюу 9,890,885.6 мянган төгрөг нь хөрөнгө оруулалтын үнэт цаас тус тус эзэлж байна.

Факторингийн тооцооны авлагын 96.4 хувь нь хэвийн, 3.6 хувь нь хугацаа хэтэрсэн авлагад ангилагдан 1,500.0 мянган төгрөгийн эрсдэлийн сан үүсгэсэн байна.

2013 оны эцэст үйл ажиллагаа явуулж буй 263 ББСБ-д 16,391,865.1 мянган төгрөгийн үндсэн ба биет бус хөрөнгө бүртгэгдэн тэдгээрт 3,819,170.2 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэн тооцон нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн байна.

2013 оны 01 дүгээр улирлаас эхлэн ББСБ-аас ирүүлж буй зохистой харьцааны тайланд шинээр нэмж тухайн улиралд олгосон зээл, эргэн төлөлтийн талаарх судалгаа, мөн оны 02 дугаар улирлын тайланд гадаадын даатгалын байгууллагад даатгагдсан эсэх талаарх судалгаануудыг авч эхэлсэн.

Дээрх олгосон зээл, эргэн төлөлтийн талаарх судалгаанд зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг нийт 219 ББСБ-аас 156 ББСБ нь буюу 59.3 хувь нь хамрагдсан бөгөөд судалгаанд хамрагдсан ББСБ-уудад тайлант хугацаанд 294,731.8 сая төгрөгийн зээл олгож, 244,587.3 сая төгрөгийн зээл эргэн төлөгдсөн байна.

Харин тайлант хугацаанд тайлан ирүүлбэл зохих нийт 263 ББСБ-аас 260 ББСБ тайлангаа ирүүлсний дотор гадаадын даатгалын байгууллагад даатгагдсан ББСБ байхгүй байна.

ДӨРӨВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ӨӨРЧЛӨЛТ

2013 оны тайлант хугацаанд ББСБ-уудын нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх онтой харьцуулж үзэхэд дараах байдалтай байна.

/Хүснэгт 11/

| № | ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ | 2012.12.31 | | 2013.12.31 | | Өөрчлөлт | |
|---|--|---------------------|-------------|----------------------|-------------|---------------------|-------------|
| | | Дүн /мян.төг/ | Хувь % | Дүн /мян.төг/ | Хувь % | Дүн /мян.төг/ | Хувь % |
| A | Өр төлбөр | 70,863,151.7 | 28.1 | 124,331,440.4 | 32.6 | 53,468,288.7 | 75.5 |
| 1 | Итгэлцлийн үйлчилгээний өглөг | 14,111,454.9 | 5.6 | 19,074,014.6 | 5.0 | 4,962,559.7 | 35.2 |
| 2 | Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг | 46,142,177.6 | 18.3 | 90,226,226.1 | 23.7 | 44,084,048.5 | 95.5 |
| 3 | Бусад эх үүсвэр | 2,547,535.8 | 1.0 | 1,879,032.6 | 0.5 | -668,503.2 | -26.2 |
| | Зээлийн батлан даалтанд байршуулсан эх үүсвэр | 300.0 | 0.0 | 0.0 | - | -300.0 | 100.0 |

ББСБ-уудын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

| | | | | | | | |
|----------|--|----------------------|--------------|----------------------|--------------|----------------------|--------------|
| | Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг | 2,547,235.8 | 1.0 | 1,879,032.6 | 0.5 | -668,203.2 | -26.2 |
| | Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг | 0.0 | 0.0 | 0.0 | - | 0.0 | 0.0 |
| | Факторингийн үйлчилгээний өглөг | 0.0 | 0.0 | 0.0 | - | 0.0 | 0.0 |
| | Гадаад валютын арилжааны эх үүсвэр | 0.0 | 0.0 | 0.0 | - | 0.0 | 0.0 |
| 4 | ББСБ-аас гаргасан өрийн бичиг | 84,605.0 | 0.0 | 1,235,000.0 | 0.3 | 1,150,395.0 | 1359.7 |
| 5 | Төслийн зээлийн санхүүжилт | 7,977,378.4 | 3.2 | 11,917,167.1 | 3.1 | 3,939,788.7 | 49.4 |
| | Бусад өр төлбөр | 9,893,730.0 | 3.9 | 22,461,359.7 | 5.9 | 12,567,629.7 | 127.0 |
| 6 | Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг | 2,300,211.4 | 0.9 | 2,280,064.3 | 0.6 | -20,147.1 | -0.9 |
| 7 | Бусад пассив | 7,593,518.6 | 3.0 | 20,181,295.4 | 5.3 | 12,587,776.8 | 165.8 |
| 8 | Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн өглөг | 0.0 | 0.0 | 0.0 | - | 0.0 | 0.0 |
| | Нийт өр төлбөр | 80,756,881.7 | 32.0 | 146,792,800.1 | 38.5 | 66,035,918.4 | 81.8 |
| Б | Эзэмшигчдийн өмч | 171,296,659.6 | 68.0 | 234,337,952.6 | 61.5 | 63,041,293.0 | 36.8 |
| 9 | Хувьцаат капитал | 137,874,226.2 | 54.7 | 183,691,627.9 | 48.2 | 45,817,401.7 | 33.2 |
| 10 | Бусад өмч | 7,579,932.97 | 3.0 | 7,181,079.0 | 27.0 | -398,854.0 | -5.3 |
| 11 | Сангууд | 108,830.8 | 0.0 | 173,557.3 | 0.0 | 64,726.5 | 59.5 |
| 12 | Хуримтлагдсан ашиг/алдагдал | 24,165,469.9 | 9.6 | 41,711,462.9 | 10.9 | 17,545,993.0 | 72.6 |
| 13 | Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/ | 1,568,199.8 | 0.6 | 1,580,225.6 | 0.4 | 12,025.8 | 0.8 |
| | НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ | 252,053,541.4 | 100.0 | 381,130,752.7 | 100.0 | 129,077,211.3 | 51.2 |

2012 оны жилийн эцсийн тайлангаар нийт эх үүсвэрийн 32.0 хувийг нийт өр төлбөр, 68.0 хувийг эзэмшигчийн өмч эзэлж байсан бол 2013 оны жилийн эцэст нийт өр төлбөр 38.5 хувь, эзэмшигчийн өмч 61.5 хувь болж өөрчлөгдсөн байна.


Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт өр төлбөр 81.8 хувиар, эзэмшигчдийн өмч 36.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Эх үүсвэрт эзлэх нийт өр төлбөр өссөн гол шалтгаан нь ББСБ-уудын дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, төслийн зээлийн санхүүжилтийн хэмжээ өссөнтэй холбоотой.


Өөрийн хөрөнгийн эх үүсвэр нэмэгдсэн нь ББСБ-уудын өөрийн хөрөнгөөр эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж, улмаар санхүүгийн тогтвортой байдлын хувьд эерэг үзүүлэлт болж байна.

ББСБ-уудын системийн нийт пассивын голлох үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.


/График 8/



/График 9/



/График 10/



2013 оны жилийн эцсийн байдлаар итгэлцлийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй 21 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 8.0 хувийг, тэдгээрийн нийт актив нийт ББСБ-ын активын 39.6 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчийн өмчийн 33.1 хувийг тус тус эзэлж байгаа ба итгэлцлийн үйлчилгээний өглөг 19,074,014.6 мянган төгрөгт хүрсэн байна.

Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 5 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаагаас 2013 оны жилийн эцсийн тайлант хугацаанд тэдгээрт 1,879,032.6 мянган төгрөгийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг бүртгэлтэй байна.

Нийт мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгийн 50.8 хувийг “Шинэ төгрөг ББСБ” ХХК, 26.6 хувийн “Мобифинанс ББСБ” ХХК-ийн цахим төлбөр тооцооны өглөг тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд Хорооны зөвшөөрөлтэйгөөр 3 ББСБ нийт 1,235,000.0 мянган төгрөгийн хаалттай өрийн бичгийг гарган бүртгүүлсэн, мөн хоёрдогч өглөгтэй 6 ББСБ-д 1,580,225.6 мянган төгрөг бүртгэлтэй байна.

ТАВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

ББСБ-уудын 2013 оны жилийн эцсийн байдлаар нийт орлого өмнөх оны мөн үеэс 52.1 хувиар өссөн ба дараах үндсэн бүтэцтэй байна.

/Хүснэгт 12/

| № | ҮЗҮҮЛЭЛТҮҮД | 2012.12.31 | | 2013.12.31 | | Өөрчлөлт | |
|---|-----------------------|---------------------|-------------|---------------------|-------------|---------------------|-------------|
| | | Дүн /мянган төгрөг/ | Хувь % | Дүн /мянган төгрөг/ | Хувь % | Дүн /мянган төгрөг/ | Хувь % |
| 1 | ХҮҮГИЙН ОРЛОГО | 45,674,078.7 | 39.3 | 66,088,468.2 | 62.0 | 20,414,389.5 | 44.7 |

| | | | | | | | |
|---|---|---------------------|--------------|----------------------|--------------|---------------------|--------------|
| | Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого | 43,343,624.9 | 37.3 | 63,343,211.3 | 59.4 | 19,999,586.4 | 46.1 |
| | Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого | 1,252,387.4 | 1.1 | 1,373,035.8 | 1.3 | 120,648.4 | 9.6 |
| | Үнэт цаасны хүүгийн орлого | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| | Бусад хүүгийн орлого | 1,078,066.4 | 0.9 | 1,372,221.1 | 1.3 | 294,154.7 | 27.3 |
| 2 | ХҮҮГИЙН БУС ОРЛОГО | 23,344,791.3 | 20.1 | 39,317,031.9 | 36.9 | 15,972,240.6 | 68.4 |
| 3 | ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО | 1,149,374.9 | 1.0 | 1,088,442.6 | 1.0 | -60,932.3 | -5.3 |
| 4 | ЕРДИЙН БУС ОРЛОГО | 314,865.9 | 0.3 | 158,143.3 | 0.1 | -156,722.6 | -49.8 |
| | НИЙТ ОРЛОГО | 70,483,110.8 | 100.0 | 106,652,086.0 | 100.0 | 36,168,975.2 | 51.3 |

Тайлант хугацааны нийт орлогын 62.0 хувийг хүүгийн орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн орлогын дүнтэй харьцуулахад 44.7 хувиар өссөн/, 36.9 хувийг хүүгийн бус орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн бус орлогын дүнтэй харьцуулахад 68.4 хувиар өссөн/ эзэлж байна.

Хүүгийн бус орлого өмнөх оны мөн үеэс 68.4 хувиар өссөн ба дараах үндсэн бүтэцтэй байна.

/Хүснэгт 13/

| № | ҮЗҮҮЛЭЛТҮҮД | 2012.12.31 | | 2013.12.31 | | Өөрчлөлт | |
|-----|--|---------------------|--------------|---------------------|--------|---------------------|--------------|
| | | Дүн /мянган төгрөг/ | Хувь % | Дүн /мянган төгрөг/ | Хувь % | Дүн /мянган төгрөг/ | Хувь % |
| 1 | Арилжааны орлого | 12,339,548.1 | 52.9 | 4,863,768.3 | 12.4 | -7,475,779.8 | -60.6 |
| 1.1 | Гадаад валютын арилжааны орлого | 10,975,889.7 | 47.0 | 4,863,423.0 | 12.4 | -6,112,466.7 | -55.7 |
| 1.2 | Үнэт цаасны арилжааны орлого | 1,363,658.4 | 5.8 | 345.4 | 0.0 | -1,363,313.0 | -100.0 |
| 2 | Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого | 7,016,892.9 | 30.1 | 28,615,644.5 | 72.8 | 21,598,751.6 | 307.8 |
| 2.1 | Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого | 6,100,891.7 | 26.1 | 26,982,916.8 | 68.6 | 20,882,025.1 | 342.3 |
| 2.2 | Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого | 916,001.1 | 3.9 | 1,632,727.7 | 4.2 | 716,726.6 | 78.2 |
| 3 | Санхүүгийн үйлчилгээний орлого | 3,988,350.3 | 17.1 | 5,837,619.1 | 14.8 | 1,849,268.8 | 46.4 |
| 3.1 | Санхүүгийн түрээсийн орлого | 2,235.0 | 0.0 | 16,089.4 | 0.0 | 13,854.4 | 619.9 |
| 3.2 | Итгэлцлийн үйлчилгээний орлого | 2,440.1 | 0.0 | 50 | 0.0 | -2,390.1 | -98.0 |
| 3.3 | Мөнгөн гуйвуулгын орлого | 815,196.9 | 3.5 | 733,005.1 | 1.9 | -82,191.8 | -10.1 |
| 3.4 | Картын үйлчилгээний орлого | 0.0 | 0.0 | 0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 3.5 | Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого | 110,691.4 | 0.5 | 752,097.1 | 1.9 | 641,405.7 | 579.5 |
| 3.6 | Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого | 2,166,701.7 | 9.3 | 3,865,787.9 | 9.8 | 1,699,086.2 | 78.4 |
| 3.7 | Бусад | 891,085.1 | 3.8 | 470,589.6 | 1.2 | -420,495.5 | -47.2 |
| | ХҮҮГИЙН БУС ОРЛОГО НИЙТ | 23,344,791.3 | 100.0 | 39,317,031.9 | 100.0 | 15,972,240.6 | 68.4 |

2012 оны жилийн эцсийн байдлаар нийт хүүгийн бус орлогын 47.0 хувийг гадаад валютын арилжааны орлого, 30.1 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 17.1 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого эзэлж байсан бол 2013 оны жилийн эцсийн байдлаар нийт хүүгийн бус орлогын 12.4 хувийг гадаад валютын арилжааны орлого, 68.6 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 14.8 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого эзэлж байна.

Нийт зардлын бүтэц дараах байдалтай байна.

/Хүснэгт 14/

| № | ҮЗҮҮЛЭЛТҮҮД | 2012.12.31 | 2013.12.31 | Өөрчлөлт |
|---|-------------|------------|------------|----------|
|---|-------------|------------|------------|----------|

ББСБ-уудын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

| | | Дүн /мянган төгрөг/ | Хувь % | Дүн /мянган төгрөг/ | Хувь% | Дүн /мянган төгрөг/ | Хувь % |
|---|--------------------------------------|---------------------------|--------------|---------------------------|--------------|---------------------------|-------------|
| 1 | ХҮҮГИЙН ЗАРДАЛ | 6,544,599.3 | 12.6 | 9,616,312.9 | 12.5 | 3,071,713.6 | 46.9 |
| 2 | ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ | 39,542,613.1 | 76.2 | 58,845,644.9 | 76.6 | 19,303,031.8 | 48.8 |
| 3 | БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН ЗАРДАЛ | 2,322,916.0 | 4.5 | 3,384,446.2 | 4.4 | 1,061,530.2 | 45.7 |
| 4 | ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | 1,016,701.4 | 2.0 | 1,224,643.3 | 1.6 | 207,941.9 | 20.5 |
| 5 | ЕРДИЙН БУС ЗАРДАЛ | 13,738.3 | 0.0 | 13,840.0 | 0.0 | 101.7 | 0.7 |
| 6 | ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ | 2,463,163.7 | 4.7 | 3,732,529.4 | 4.9 | 1,269,365.7 | 51.5 |
| | НИЙТ ЗАРДАЛ | 51,903,731.8 | 100.0 | 76,817,416.7 | 100.0 | 24,913,684.9 | 48.0 |

2013 оны жилийн эцсийн байдлаар нийт зардал өмнөх оны мөн үеэс 48.0 хувиар өссөнөөс хүүгийн зардал 46.9 хувиар, хүүгийн бус зардал 48.8 хувиар, болзошгүй эрсдэлийн зардал 45.7 хувиар, үндсэн бус үйл ажиллагааны зардал 20.5 хувиар, ердийн бус зардал 0.7 хувиар, орлогын татварын зардал 51.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

ББСБ-ын 2013 оны жилийн эцсийн нийт орлого өмнөх оны мөн үеэс 51.3 хувиар, нийт зардал 48.0 хувиар тус тус өссөн байна.


2013 оны жилийн эцсийн байдлаар нийт 29,834,669.3 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 60.6 хувиар өссөн байна.

/Хүснэгт 15/

| № | ҮЗҮҮЛЭЛТҮҮД | 2012.12.31 | 2013.12.31 | Өөрчлөлт |
|---|-----------------------------------|------------------------|------------------------|------------------------|
| | | Дүн /мянган төгрөг/ | Дүн /мянган төгрөг/ | Дүн /мянган төгрөг/ |
| 1 | НИЙТ ОРЛОГО | 70,483,110.8 | 106,652,086.0 | 36,168,975.2 |
| 2 | НИЙТ ЗАРДАЛ | 51,903,731.8 | 76,817,416.7 | 24,913,684.9 |
| | ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШИГ | 18,579,379.1 | 29,834,669.3 | 11,255,290.2 |

ББСБ-уудын нийт орлого, зардлын үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

/График 11/



Өмнөх онтой харьцуулахад системийн хувьд нийт ашиг нэмэгдсэн нь ББСБ-уудын активын өсөлт, ББСБ-ын тооны өсөлт тэдгээрийн үйл ажиллагааны үр ашиг нэмэгдэж байгаатай шууд холбоотой байна.

Тайлант жилд 207 ББСБ буюу нийт ББСБ-ын 78.7 хувь нь 32,284,514.0 мянган төгрөгийн ашигтай, 39 ББСБ буюу нийт ББСБ-уудын 14.8 хувь нь 2,449,844.8 мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж тэдгээрийн нийт цэвэр ашиг 29,834,669.3 мянган төгрөгт хүрсэн байна.

ЗУРГАА. БҮЛГИЙН САНХҮҮГИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Нийт ББСБ-уудыг активын хэмжээгээр нь 400,000.0 мянган төгрөг хүртэл активтай, 400,000.0 мянган төгрөгөөс 1.0 тэрбум төгрөг хүртэл активтай, 1.0 тэрбум төгрөгөөс 5.0 тэрбум төгрөг хүртэлх активтай, 5.0 тэрбум төгрөг ба түүнээс дээш төгрөгийн активтай ББСБ гэсэн 4 бүлэгт хуваан тооцов.

2013 оны жилийн эцсийн байдлаарх бүлгүүдийн бүтэц дараах байдалтай байна:

/Хүснэгт 16/

| № | Бүлэг | Бүлэгт хамаарах ББСБ-ын тоо | Бүлгийн нийт актив | | Нэмэлт мэдээлэл |
|-------------|----------|-----------------------------|-----------------------|---------------------------------|--|
| | | | Актив /мянган төгрөг/ | Нийт активт эзлэх хэмжээ /хувь/ | |
| 1 | Бүлэг 01 | 18 | 210,030,754.2 | 55.1% | 5.0 тэрбум төгрөгнөөс дээш активтай |
| 2 | Бүлэг 02 | 47 | 93,410,281.5 | 24.5% | 1.0 тэрбумаас 5.0 тэрбум төгрөг хүртэлх активтай |
| 3 | Бүлэг 03 | 124 | 66,799,505.7 | 17.5% | 400,000.0 мянган төгрөгөөс 1.0 тэрбум төгрөг хүртэл хэмжээний активтай |
| 4 | Бүлэг 04 | 74 | 10,890,211.2 | 2.9 | 400,000.0 мянган төгрөг хүртэл хэмжээний активтай |
| НИЙТ | | 263 | 381,130,752.7 | 100.0% | |

2013 оны жилийн эцсийн байдлаарх бүлгүүдийн тайлант үеийн ашиг дараах байдалтай байна. Үүнд:

/Хүснэгт 17/

| № | ҮЗҮҮЛЭЛТ | Нийт актив /мянган төгрөг/ | Дүрмийн сан /мянган төгрөг/ | Тайлант хугацааны цэвэр ашиг /мянган төгрөг/ | Салбарын нийт татварын дараах цэвэр ашигт эзлэх хувь |
|-------------|----------|----------------------------|-----------------------------|--|--|
| 1 | Бүлэг 01 | 210,030,754.2 | 61,642,632.1 | 14,949,488.7 | 50.1 |
| 2 | Бүлэг 02 | 93,410,281.5 | 55,149,274.5 | 10,345,597.4 | 34.7 |
| 3 | Бүлэг 03 | 66,799,505.7 | 56,750,485.8 | 4,440,485.1 | 14.9 |
| 4 | Бүлэг 04 | 10,890,211.2 | 10,149,235.4 | 99,098.1 | 0.3 |
| НИЙТ | | 381,130,752.7 | 183,691,627.8 | 29,834,669.3 | 100.0% |

Бүлгүүдийн актив, ашгийн үзүүлэлтүүдийг харьцуулан харахад “Бүлэг 01”-д хамаарах 18 ББСБ нь нийт ББСБ-уудын 6.8 хувийг эзэлж байгаа боловч эдгээр компаниудад нийт ББСБ-уудын актив хөрөнгийн 55.1 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгийн 33.6 хувь, татварын дараах цэвэр ашгийн 50.1 хувийг тус тус эзэлж байгаа нь салбартаа голлох байр суурийг эзэлж байна.

ДОЛОО. САЛБАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

ББСБ-ын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүд системийн түвшинд дараах байдалтай байна. Үүнд:

- нийт өөрийн хөрөнгө 234,399,453.1 мянган төгрөг, эрсдэлээр жигнэсэн актив 263,087,937.8 мянган төгрөг байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлт нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын хувьд 88.0 хувь, өөрийн хөрөнгийн хувьд 90.0 хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын хувьд 60.8 хувь;

- түргэн борлогдох актив 85,966,981.4 мянган төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 103,614,017.4 мянган төгрөг байгаагаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 83.0 хувь;

- валютын дансны цэвэр зөрүү 17,297,260.2 мянган төгрөг, тухайн валютаарх өөрийн хөрөнгө 236,882,996.8 мянган төгрөг байгаагаас нийт гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа 7.3 хувь;

- итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийн үлдэгдэл 19,074,014.6 мянган төгрөг, өөрийн хөрөнгө 234,399,453.1 мянган төгрөг байгаагаас итгэлцлийн үйлчилгээний өглөг, өөрийн хөрөнгийн харьцаа 8.14 хувь;

- нийт зээлийн өрийн үлдэгдэл 223,711,713.9 мянган төгрөг, үүнээс чанаргүй зээл 8,795,068.7 мянган төгрөг байгаагаас нийт зээл чанаргүй зээлийн харьцаа 3.9 хувь;

- нийт цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө 5,461,180.8 мянган төгрөг, нийт актив 381,130,752.7 мянган төгрөг байгаагаас үндсэн хөрөнгө, нийт активын харьцаа 1.4 хувь байгаа нь зохистой харьцааны үзүүлэлтүүдийг тус тус хангасан байна.

Харин активын эрсдэлийн санг 6,280,211.4 мянган төгрөгөөр байгуулбал зохихоос 531,652.4 мянган төгрөгөөр илүү буюу нийт 6,811,863.8 мянган төгрөгөөр байгуулсан байна.²

Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2010 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 475/182 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу ангилж, активын эрсдэлийн санг үнэн зөв байгуулах шаардлагатай байна.

НАЙМ. ДҮГНЭЛТ

1. 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлд тайлан ирүүлбэл зохих нийт 263 ББСБ-аас 260 ББСБ буюу 98.9 хувь нь тайлангаа ирүүлсэн ба 16 ББСБ буюу 6.1 хувь нь эхлэлтийн санхүүгийн тайлангаар болон өмнөх үеүүдийн санхүүгийн тайлангийн дүнгээр хамрагдсан байна.
2. ББСБ-уудын дийлэнх хэсэг нь зээл, гадаад валютын үйл ажиллагааг дагнан болон зэрэг эрхлэж байна. Нэр бүхий 33 ББСБ банк бус санхүүгийн үйл ажиллагааны төрлүүдээс 3-4 төрлийн үйл ажиллагааг зэрэг эрхлэхээр тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.8 хувиар өссөн хэдий боловч ББСБ-уудын тооны өсөлттэй харьцуулахад төдийлөн ахиц гараагүй, энэ нь ББСБ-ын хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө санхүүгийн чадвараас хамаарч үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх хандлага сул байгаатай холбоотой.
3. ББСБ-уудын голлох үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт актив 129,077,211.3 мянган төгрөг буюу 51.2 хувь, нийт зээлийн өрийн үлдэгдэл 65,942,368.1 мянган төгрөг буюу 41.8 хувь, эзэмшигчдийн өмч 63,041,293.0 мянган төгрөг буюу 36.8 хувь, нийт дүрмийн сан 44,497,401.6 мянган төгрөг буюу 32.0 хувиар тус тус өссөн байна.
4. ББСБ-уудын нийт актив 2013 оны жилийн эцсийн байдлаар 381,130,752.7 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт активтай харьцуулахад **/банкны салбарын нийт актив 20,883,711,141.9 мянган төгрөг/** 1.8 хувь, нийт зээлийн өрийн үлдэгдэл 223,711,713.9 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт зээлтэй харьцуулахад **/банкны салбарын нийт зээл 10,840,231,413.6 мянган төгрөг/** 2.1 хувь, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл

² Энэхүү тоон үзүүлэлтийг гаргахдаа тухайн ББСБ-уудын ТОП20 зээлдэгчийн мэдээлэлд тулгуурлан гаргасан болно.

ББСБ-уудын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

8,541,119.0 мянган төгрөг байгаа нь банкны салбарын чанаргүй зээлтэй харьцуулахад /банкны салбарын чанаргүй зээл 564,239,634.1 мянган төгрөг/ 1.5 хувь, нийт дүрмийн сан 183,691,627.8 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт дүрмийн сантай харьцуулахад /банкны салбарын нийт дүрмийн сан 363,062,487.7 мянган төгрөг/ 50.6 хувьтай тус тус тэнцэж байна.

5. 2013 онд Хороонд төвлөрүүлбэл зохих нийт 212 ББСБ-ын 207,115.0 мянган төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөгдөхөөс 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 211 ББСБ-ын 207,220.0 мянган төгрөгийг Хорооны дансанд төвлөрүүлсэн нь 99.9 хувьтай байна.

ЕС. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛБЭЛ ЗОХИХ АРГА ХЭМЖЭЭ

Тус газраас 2014 онд дараах асуудалд анхаарч ажиллах шаардлагатай байна.

1. ББСБ-уудаас хүлээн авах санхүүгийн тайлан мэдээ, мэдээллийг цуглуулах мэдээллийн цахим сан, нэгдсэн сүлжээг сайжруулах;
2. УИХ-аас 2011 оны 10 дугаар сарын 20-ны өдөр батлан гаргасан Зээлийн мэдээллийн тухай хуулийн 9.1.7-д “Банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо нь Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд шаардлагатай мэдээллийг өгөх, авах гэрээг байгуулж, мэдээлэл солилцох үүрэг хүлээх” гэсэн заалтын дагуу ББСБ-уудыг зээлийн мэдээллийн санд бүрэн хамруулах;
3. Зээл, зээлтэй адилтган тооцох активыг Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2010 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 475/182 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу ангилж хэвшүүлэх;
4. Хөдөө орон нутаг дахь ББСБ-уудын үйл ажиллагаанд гүйцэтгэх газар дээрх хяналт, шалгалтын ажлыг идэвхижүүлэх;
5. Үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, санхүү, төлбөрийн чадварыг тогтворжуулах, хууль, журмын хэрэгжилтийг хангуулах зорилгоор ББСБ-уудын удирдлага, ажилтнуудад зориулсан сургалтыг зохион байгуулах, сургалтын үр өгөөжийг дээшлүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР

31/12/2013

| ҮЗҮҮЛЭЛТҮҮД | НИЙТ | | ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ | | ЗӨВХӨН ГАДААД ВАЛЮТЫН ЭРХТЭЙ | | ХӨДӨӨ ОРОН НУТАГ | |
|--|----------------|--------|------------------------------|--------|------------------------------|--------|------------------|--------|
| | ДҮН | ХУВЬ | ДҮН | ХУВЬ | ДҮН | ХУВЬ | ДҮН | ХУВЬ |
| ХӨРӨНГӨ | | | | | | | | |
| Эргэлтийн хөрөнгө | 368,558,057.77 | 96.70% | 49,527,540.87 | 96.95% | 8,078,621.00 | 95.29% | 6,783,929.07 | 93.05% |
| Мөнгөн хөрөнгө | 113,684,987.46 | 29.83% | 6,742,854.97 | 13.20% | 7,839,112.94 | 92.46% | 1,139,885.09 | 15.63% |
| Бэлэн мөнгө | 42,193,090.80 | 11.07% | 1,312,721.75 | 2.57% | 7,832,654.71 | 92.38% | 877,146.15 | 12.03% |
| Банкинд байршуулсан харилцах | 28,179,928.83 | 7.39% | 2,261,963.38 | 4.43% | 6,242.88 | 0.07% | 199,555.49 | 2.74% |
| Банкинд байршуулсан хадгаламж | 6,436,447.08 | 1.69% | 937,804.79 | 1.84% | 0.00 | 0.00% | 63,183.46 | 0.87% |
| Санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах | 34,731,874.06 | 9.11% | 86,718.35 | 0.17% | 215.35 | 0.00% | 0.00 | 0.00% |
| Санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж | 2,143,646.69 | 0.56% | 2,143,646.69 | 4.20% | 0.00 | 0.00% | 0.00 | 0.00% |
